



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 23

Төрийн ордон, Улаанбаатар хот

“Монголын нууц товчоо”-г мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай

Монголын ард түмэн олон зууныг өртөөлсөн үндэсний соёлын гайхамшигт өв санг бүрдүүлсний дотор ном судрыг эрдмийн дээд эрдэнэ хэмээн сүслэн бүтээж, үнэт эдээр баримтаглан өргөө гэрийнхээ хойморт залж, ур удмаараа гэгээрч боловсрон, дээдлэн хадгалж ирсэн гэгээн уламжлалтай билээ.

"Монголын нууц товчоо" бол Монголын их хаадын угсаа гарвал, монголчуудын ахуй амьдрал, үндэсний түүх, хэл бичиг, утга соёл, ардын аман зохиол, бөө мөргөл, зан заншлын их нэвтэрхий толь, монгол хэлний угийн урлагийн сонгодог бүтээл, нүүдэлчний соёлын үл давтагдах хосгүй шинж чанараараа ижилгүй товойж, үеийн үед гайхагдсаар эрин зууныг эзэлсэн их туульс, "тал нутгийн анхилам үнэр нэвт шингэсэн туух, он цагийн дарааллын бичиг мөн".

Монголын бичмэл түүхэн сурвалжийн ууган дээж бичиг, эртний монгол уран зохиолын гайхамшигт дурсгал энэхүү өв тэгш туурвилыг даяар олноороо Мөнх эрхэмлэн, үндэсний бахархлын эрх дархтайгаар дээдлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх заалтын 3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ нь:

1. Шижир алт, цалин цагаан мөнгөөр чимэглэсэн, эрдэнийн чулуун Шигтгээт хосгүй нэг хувь "Монголын нууц товчоо"-г урлан бүтээж Төрийн хүндэтгэлийн өргөөний хойморт залсугай.

2. "Монголын нууц товчоо"-г айл өрх бүр өргөө гэрийнхээ хойморт залж, сүслэн дээдэлж байхыг Монголын нийт ард иргэдэд зөвлөсүгэй.

3. "Монголын нууц товчоо"-г цогц хандлагаар эрчимтэй судалж, бүх шатны боловсролын байгууллагын суралцагсдад үе шаттай судлуулахыг нийт эрдэмтэд, судлаачид, багш сурган хүмүүжүүлэгчдэд уриалсугай.

4. Төрийн хүндэтгэлийн өргөний хойморт залах "Монголын нууц Товчоо"-г урлан бүтээхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Н.БАГАБАНДИ

Н.ЭНХБАЯР



ХУУЛБАР ҮНЭН:
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

B. Ochirbat

Б. Очирбат